

# ХОВД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ

## ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.06.07

Монгол улсын засгийн газрын болон УБЕГ-ын бодлого шийдвэрийг орон нутгийн түвшинд зохион байгуулж хэрэгжилтийг хангуулан төрийн албан хаагчдыг мэдлэг чадвартай, мэргэшсэн, сахилга хариуцлага, ёс зүйтэй байлгах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, чанарын өндөр түвшинд хүргэх, иргэдийн бүртгэлийн байгууллагад эерэг хандах хандлагыг сайжруулахад гол зорилгоо болгон ажиллаж байна.

Монгол улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл, Алсын хараа 2050, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Цахимын багц хууль тэр тусмаа цахим гарын үсгийн хуулийн хээгжилтийг хангуулах, Улсын бүртгэлийн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө, Ухаалаг засаглал төслийн хүрээнд Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах иргэдэд үзүүлэх үйлчилгээг авилгагүй, хүнд сурталгүй, цаасгүй, зардалгүй байх ажлыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, цахим бүртгэлүүдийг орон нутгийн иргэдэд ойлгуулах, цахим хэрэглээг нэвтрүүлэхэд анхаарч бүртгэлийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах боломжийг иргэдэд хүргэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж холбогдох дээд байгууллагаас ирүүлсэн чиглэл зөвлөмжийг цаг тухай бүрд нь улсын бүртгэгч нарт хүргүүлэн ажиллаа.

### **ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ**

- 1.Иргэний бүртгэлийн чиглэлээр
- 2.ЭХЭУБ-ийн чиглэлээр
- 3.Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр
- 4.Хяналт шалгалтын чиглэлээр
- 5.Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн чиглэлээр
- 6. Төсөв санхүүгийн чиглэлээр
- 7. Мэдээлэл технологи, техник тоног төхөөрөмжийн талаар
- 8. Эрх зүй, сургалт сурталчилгааны талаар
- 9.Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан талаар
- 10.Идэвхи санаачлага, шинэлэг ажлын талаар

#### **1.Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

##### **1.1. Иргэний гэр бүлийн 8 төрлийн бүртгэл:**


2021 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр нийт 17643 иргэнд үйлчилгээ үзүүлэн ажилласан байна.Үүнд:



ᠮᠣᠩᠭᠡᠯ  
ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ

# ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТАСАГ

Иргэний 8 төрөл 2020-2021 он



[www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn)

1. Төрсний бүртгэлд тайлант онд 1876 хүүхэд төрж бүртгүүлснээс эрэгтэй 964 эмэгтэй 912 хүүхэд төрсөн байна.

2. Үрчлэлтийн бүртгэлээр -38

3. Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлээр-75

4. Эцэг тогтоосны бүртгэлээр-64

5. Гэрлэсний бүртгэлээр -574 бүртгэснээс анхны -545, дахин-29 иргэний гэрлэлтийг бүртгэсэн байна.

6. Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл -32 бүртгүүлснээс захиргааны журмаар 11, шүүхийн журмаар 21 гэр бүлийн цуцлалтыг бүртгэсэн байна.

7. Нас барсны бүртгэл-436- ийг бүртгэж нийт иргэний 8 төрлийн бүртгэлийн чиглэлээр 3094 бүртгэлийг сумдаас хүлээн авч мэдээллийн санд шалган шивж баталгаажууллаа

## **1.2.Шилжилт хөдөлгөөний бүртгэл:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/215 тоот тушаал, УБЕГ-ын дэд даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн /2330 тоот чиглэл, Хяналт шалгалтын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 8/2473 тоот чиглэл зөвлөмжүүдийг тус тус үндэслэн шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой ажлуудыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэгт заасны дагуу “Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлийг МУЕС-ийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн дүнг нийтэд мэдээлэх өдрийг дуустал 04 дүгээр сарын 09 -ний өдрийн 18 цаг -00 минутанд зогсоож, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сэргээсэн.

Ховд аймгийн онцгой комиссын шийдвэрээр хатуу хөл хорио тогтоосон хэдий ч сумдад бүртгэгдсэн 23 ширхэг ИУБ-22 маягтуудыг дотоод сүлжээ мэйл хаягаар хүлээн авч мэдээллийн санд бүрэн баталгаажуулан ямар нэгэн санал гомдол, зөрчил гараагүй болно.

2021 оны жилийн эцсийн байдлаар 2795 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл хийгдсэн байна.

Улаанбаатар хот болон бусад аймгаас шилжин ирсэн 508 иргэн шилжин ирж бүртгэгдсэнээс, насанд хүрэгч 328, хүүхэд 180 иргэн байгаагаас аймгийн доторх шилжилт хөдөлгөөнд 1091 иргэн, үүнээс 663 насанд хүрэгч, хүүхэд 428 , бүртгэгдсэн байна.

Баг хоорондын шилжилт хөдөлгөөний бүртгэл 1196 хийгдсэн байна. Үүнээс насанд хүрэгч-731 , хүүхэд - 465 байна.

Тайлант онд хаягжуулалтын хуулийн дагуу тус аймгийн хэмжээнд шинээр баригдсан барилга байгууламж, орон сууцны эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг үндэслэн иргэний улсын бүртгэлийн хаягийн мэдээллийн санд 38 хаягийн бүртгэлийг нотлох баримтыг хамт албан тоотоор хүргүүлэн мэдээллийн санд тусгууллаа.

Аймгийн хэмжээнд хаягжуулалтын тухай хуулийн дагуу хаяг нь өөрчлөгдсөн боловч ИУБ-ийн мэдээллийн санд тусгагдаагүй 1526 хаяг, ЭХЭУБ-ийн гэрчилгээн дэхь хаяг нь ИУБ-ийн мэдээллийн сантай зөрсөн - 736 хаяг, хаягийн бичвэрийн зөрүүтэй – 1658 хаягийн судалгааг тус тус гаргаж хүргүүллээ.



### 1.3. Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл:

Жилийн эцсийн байдлаар үндэсний энгийн гадаад паспорт авахаар хүсэлтээ ирүүлсэн иргэдээс 622 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт олгосон. Үүнээс 16 –аас доош 29 хүүхдэд гадаад паспорт олгож, насан хүрэгчдэд 593 гадаад паспортыг тус тус олгосоноос E Mongolia -р 118 гадаад паспорт захиалж авсан байна.

Тайлант онд 405 иргэний гадаад паспортыг хүчингүй болгосныг ангилбал:

Хугацаа болон хуудас дууссан- 39, гэмтээсэн -10, визний шаардлагаар-5 паспортыг тус тус хүчингүй болгосон байна. БНХАУ-ын хил нээгдээгүйн улмаас Булган сумын Байтаг, Булган боомтоор хил нэвтрэх үнэмлэх олгоогүй байна.



### 1.4. Регистрийн дугаар өөрчилсөн талаар:


Эхний 11 сарын байдлаар регистрийн дугаар өөрчлүүлэх хүсэлт гаргасан иргэдэд холбогдох ХУБ-ийн дүгнэлтийг үндэслэн 21 иргэний регистрийн дугаарыг нь өөрчлөн УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт албан тоотоор хүргүүлэн шинээр олгосон регистрийн дугаарыг нь мэдээллийн санд баталгаажууллаа.

Шинээр олгосон регистрийн дугаараар цахим үнэмлэхээ сольж авах зөвлөлгөө өгсний дагуу дээрх иргэд холбогдох материалаа бүрдүүлэн ирснээр цахим үнэмлэхийг дахин олгосон.



## ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТАСАГ

Регистрийн дугаар өөрчилсөн бүртгэл  
/2020-2021 оны жилийн эцсийн байдлаар/



www.burtgel.gov.mn

### 1.5. Бүртгэлд засвар өөрчлөлт оруулсан талаар

1. Сум дундын иргэний анхан шатны шүүхийн шийдвэрээр үрчлэлтийн бүртгэлээ хүчингүй болгосон 4 иргэний хүсэлтийн дагуу үрчлэлтийн бүртгэлийг мэдээллийн санд хүчингүй болгох засвар өөрчлөлтийн маягтыг бичиж, шүүхийн шийдвэр, албан тоотын хамт УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн анхны бүртгэлд нь оруулсан.

2. Иргэний баримтын архивын журнал болон цахим архивын нотлох баримтаас зөрүүтэй мэдээллийн санд үг, үсгийн алдаатай тусгагдсан -258 иргэний бүртгэлд, ХУБ-ийн дүгнэлтээр -11 иргэний бүртгэлд нийт 269 иргэний бүртгэлийг засвар өөрчлөлтийн бүртгэлээр мэдээллийн санд залрууллаа.

Үүнээс: Ургын овог- 201, Эцгийн нэр-26, Өөрийн нэрний үсгийн алдаа-42


### **1.6. Нөхөн бүртгэлийн талаар**

Нөхөн бүртгэлийн чиглэлээр дараах бүртгэлүүдийг архивын нотлох баримтаас татан нөхөн хуулбарлан албан тоотоор хүргүүлэн мэдээллийн санд оруулснаас :

- ХААТР-11-70 ш
- ХААТР-12 -4 ш
- ХААТР-15-7 ш
- ХААТР-18 -1 ш нийт 82 ш маягтуудыг мэдээллийн санд нөхөн бүртгэлээр тусгуулан ажиллалаа.

Мэдээллийн санд нас барсны бүртгэл нь тусгагдаагүй, регистрийн дугаар олгогдоогүй, иргэдийн нас баралт бүртгэгдсэн бүртгэлийн дэвтрийн журнал, нас барсан тухай лавлагааг нь иргэний улсын бүртгэлийн газарт албан тоотоор

хүргүүлэн 13 иргэнд тусгай сери бүхий регистрийн дугаар олгож нас барсан бүртгэлийг нөхөн оруулж өгсөн.



### 1.7.ИШБ, Цахим үнэмлэх олголтын талаар

2021 оны жилийн эцсийн байдлаар 3729 иргэний цахим үнэмлэхний санд тулгаж баталгаажуулан хэвлүүлж эздэд нь олголоо. Үүнийг захиалгын ангиллаар харуулбал: 16 насанд хүрсэн -1284, 25 насны сунгалт -1097, 45 насны сунгалт 822 дахин олголт 526 тус тус олгосон байна.

Шинээр 16 нас хүрсэн иргэдийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулахдаа бүртгэгч нарын хайнга санамсаргүй байдлаас ИУБ-31 маягтанд дээр гаргаж байгаа алдаан дээр онцгой анхааран ажиллаж 11 иргэний бүртгэлд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулан зөрчил арилган иргэдийг цахим үнэмлэхжүүллээ. Шинэчилсэн системд нэвтэрч орсноор иргэний шинэчилсэн бүртгэлд анх удаа, 25,45 насны сунгалт хийлгэж буй иргэний хурууны хээ авах программ нь онлайн системд нэвтэрснээр ямар нэгэн зөрчил гарах явдал арилж байна.

Цаашид ийм алдааг дахин давтан гаргахгүй байх тал дээр нь анхаарч сумдын бүртгэгч нарт 2 удаагийн чиглэлийг хүргүүлэн ажилласан. Сумдаас бүртгэгдэн ирж буй биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн ИУБ -31 маягтыг хүлээн авч галиглан ИБ-н газарт жагсаалтаар сар бүр тогтсон хугацаанд нь хүргүүлэн хэвшсэн. Гээж үрэгдүүлсэн цахим үнэмлэхээ захиалах иргэдэд чирэгдэл үүсгэхгүйн тулд E-mongolia системд хандаж үнэмлэх захиалах зааварчилгаа өгсний дагуу 389 иргэн цахимаар захиалсан.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Улсын бүртгэлийн ерөнхий газар, "Иргэний шилжин суурьших хөдөлгөөний цахим бүртгэл төслийг хамтран хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлд бүртгүүлэх үйлчилгээний үнэ хөлс хураамжаа төлөх боломжгүй зэрэг асуудлаас шалтгаалан оршин суух хаяггүй, биеийн давцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлээгүй, 25, 45 насанд хүрсэн боловч хууль тогтоомжид заасан хугацаанд иргэний үнэмлэхээ солиулаагүй зорилтот бүлгийн 50 иргэний материаллыг холбогдох газарт хүргүүлж ажилласны дагуу эхний 6 иргэний цахим үнэмлэхийг үнэ төлбөргүй олгож өглөө.

Сумдаас ирүүлж буй цахим үнэмлэхний тооцоог тухай бүр нь тулган шалгаж авснаар сар бүрийн 25 нд нягтлан бодогч, нярав нартай үнэт цаас ашигласны тооцоог хийж хэвшсэн.



### 1.8. Иргэний баримтын архивын лавлагаа үйлчилгээ

Иргэний бүртгэлийн архиваас 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 7030 лавлагаа гаргаснаас хууль хяналтын байгууллагад 1012, иргэдэд 3606, албан хэрэгцээнд 2412 лавлагаа олгож үйлчиллээ

Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж, эх нотлох баримтыг бүрэн цахимжуулснаар УБЕГ-ын нэгдсэн архиваас олгодог лавлагааг орон нутгаас олгож иргэдийг орон зайнаас үл хамааран архивын үйлчилгээг авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.



Иргэний 8 төрлийн бүртгэлээр сумдаас бүртгэгдэн ирж буй ИУБ-11-1876, ИУБ-12-38, ИУБ-13-75, ИУБ-14-64, ИУБ-15-574, ИУБ 16-32, ИУБ 18-436, ИУБ-22- ш 1722 маягт, ИУБ-31- 3729 ш маягт, нийт – 8546 ш маягтуудыг хүлээн авч галиглан хувийн хэрэгт нь байршуулсан.

Хяналтын улсын байцаагч болон холбогдох хэлтсийн иргэний улсын бүртгэгч нарт лавлагаа мэдээлэлд болон дүгнэлт гаргуулахаар 2319 ширхэг хувийн хэрэг татан өгснөөс 2313 ш маягыг буцаан байршуулж, 6 иргэний маягт хяналтанд байна. Шүүх цагдаа хууль хяналтын байгууллагаас 25 иргэнд холбогдох архивын нотлох баримтыг эх хувиас нь хуулбарлаж ирүүлэх албан тоотын дагуу архивын журналаас хуулбарлан хуулбар тэмдэг дарж холбогдох газарт нь хүргүүлсэн.

Бусад аймаг хотоос шилжин ирсэн иргэдийн хувийн хэргийг байршуулан, шилжин явсан иргэдийн хувийн хэргийг холбогдох аймгуудад нь албан тоотоор хүргүүллээ. Тус хэлтэст цахим үнэмлэхээ захиалсан, гэрлэлтээ батлуулсан, нас баралт бүртгүүлсэн иргэдийн холбогдох маягтуудыг харъяалагдах газарт нь жагсаалт үйлдэн хүргүүллээ. Монгол улсын их хурлын 2020 оны сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуулийн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн нэрийн жагсаалтыг товъёоглон иргэний баримтын архивт түр хадгаллаа.





Тайлант онд Иргэний баримтын архиваас олгосон лавлагааг төрлөөр нь авч үзвэл:

1. Төрөлт бүртгэлийн лавлагаа -1216
2. Үрчилсний бүртгэлийн лавлагаа -62
3. Овог нэр өөрчлөлтийн лавлагаа - 160
4. Эцэг тогтоолтын лавлагаа - 50
5. Гэрлэсний бүртгэлийн лавлагаа -347
6. Гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа - 190
7. Гэрлэлт дуусгавар болсны лавлагаа- 24
8. Нас барсны лавлагаа -313
9. Иргэний цахим үнэмлэхний лавлагаа -690
10. ХААТР-1 маягтын лавлагаа -95
11. Төрөл садангийн лавлагаа -199
12. Оршин суугаа хаягын лавлагаа - 207
13. Регистр өөрчилсөн лавлагаа -40
14. Гадаад паспорт олголтын лавлагаа- 7
15. Төрөлт бүртгэлгүй -6

иргэнд лавлагааг тус тус олгож нийт 3606 иргэнд үйлчилсэн байна.


Хууль хяналтын байгууллагын хүсэлтээр 1012 иргэдийн иргэний бүртгэлтийн талаарх мэдээллийг цаг тухай бүр нь гарган хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

Хууль хяналтын байгууллагад хүргүүлсэн лавлагааг төрлөөр нь ангилбал: Цахим үнэмлэхний -473, Оршин суугаа хаягийн - 351, Төрсний бүртгэлийн лавлагаа-64, Гэрлэсэн эсэх лавлагаа -18, Нас барсны бүртгэлийн лавлагаа -16, Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа-48, төрөл садангийн-37, овог нэр, нэр өөрчилсний лавлагаа -2, регистрийн дугаар өөрчилсний лавлагаа -1 ,ХААТР-1 маягт-1, төрөлт бүртгэлгүй-1 нийт -1012 лавлагааг хүргүүлсэн.



МОНГОЛ  
УЛСЫН  
АРХИВ

## Архиваас олгосон 2020-2021 оны лавлагааны тоо



www.burtgel.gov.mn

Иргэний улсын бүртгэлийн тасгийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэлтсийн иргэний баримтын архивт хадгалагдаж буй хувийн хэргийн тооллого мөн тодорхойгүй төлөвт иргэдийн хувийн хэргийг тоолж excel программд шивж дуусгах ажлыг зохион байгууллаа. Энэ ажлыг дурьдсан хугацаанд нь хийж хэрэгжүүлэх үүднээс иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч, архивч нарт 2021 оны 08 дугаар сарын 01-ний дотор тоолж дуусгах хуваарь гарган хуваарилан өгч амжилттай хийж дуусгалаа.

Үүнд: Иргэний баримтын архивт өнөөдрийн байдлаар 123840 ширхэг хувийн хэрэг байршиж байна.

Иргэний баримтын архивт хадгалагдаж буй тодорхойгүй төлөвт, хаяггүй 9 хайрцагт байршиж буй иргэдийн хувийн хэргийг ангилан ялгаж excel програмд шивж дуусгалаа. Тодорхойгүй төлөвт хаяггүй 9 хайрцаганд 5350 ширхэг тодорхойгүй хаягтай иргэдийн хувийн хэрэг байршиж байна.




## 2. ЭХЭУБ-ийн чиглэлээр

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 10117 иргэн, хуулийн этгээдээс мэдүүлэг хүлээн авч 9976 мэдүүлэгт бүртгэл хийж 115 мэдүүлгийг нотлох баримтын шаардлага хангуулахаар буцаан ажилласан байна.

Эд хөрөнгө өмчлөх эрхийг анхны удаа бүртгэж баталгаажуулахад бүрдүүлэх материалын жагсаалтыг боршур хэлбэрээр болон үйлчилгээний заалны самбарт байршуулан нотлох баримтыг үнэн зөв бүрдүүлэлтэнд анхаарал хандуулан ажиллаж Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх бүртгэл 412, Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх бүртгэл 236, төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх бүртгэл 209, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх бүртгэл 15-ийг бүртгэж өмчлөх эрхээ анх удаа баталгаажуулсан анхны бүртгэлийн 872 өмчлөх эрхийн гэрчилгээ бичиж олгосон.

Мөн газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар хоёрын хоорондох газрын дугаар олгох системийн хүрээнд нийт 958 иргэн хуулийн этгээдэд газар эзэмших “Э” дугаар, 5 иргэн хуулийн этгээдэд газар ашиглах “А” дугаар олголоо.



Гэрээ эрхийн үндсэн дээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл буюу Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл Газраас бусад-46

Газар-54,

Бэлэглэх гэрээ газраас бусад-51

Газар-44

Худалдах худалдан авах гэрээ газраас бусад-420

Газар-385

Өмчлөгч


өөрт ногдох хэсгээ худалдах, бэлэглэх гэрээ газраас бусад-51

Газар-61

Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл-3-ийг тус тус бүртгэл хөтөлж ажилласан.

Бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл буюу эд хөрөнгийн хаяг, зориулалт, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх, эд хөрөнгийн хэмжээ, үнэ гүйцэтгэл өөрчлөгдөх, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх, өмчлөгчийн овог нэр, регистрийн дугаар өөрчлөгдөх бүртгэл нийт 305-ийг бүртгэж архивлан архивын нэгж үүсгэн ажиллаа.

Улсын ерөнхий бүртгэгчийн тушаалаар хувийн хэрэг хаах бүртгэл-8, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хаяж үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох бүртгэл 16, гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох бүртгэл 1-г тус тус бүртгэсэн байна.



Банк болон банк бус санхүүгийн байгууллага иргэн хуулийн этгээдийн хооронд байгуулсан барьцаалбартай барьцааны гэрээ-1705, барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах бүртгэл 156, барьцаалбаргүй барьцааны гэрээ 2266, барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах бүртгэл 115, барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэл 3123 бүртгэж архивын хувийн хэрэгт баяжилт хийсэн байна. 2021 онд нийт 4246 барьцааны гэрээ бүртгүүлэх мэдүүлэг хүлээн авч 377746915 төгрөгний үйлчилгээний хураамжийг төвлөрүүлж ажилласан байна. Үүнээс 2495 иргэн, хуулийн этгээд орон сууц барьцаалж 153.777.791.391 төгрөгний зээлийн гэрээ бүртгүүлсэн байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоол, 2020 оны 230 дугаар тогтоолыг өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж 4626041 төгрөгний

тэмдэгийн хураамж, 405173355 төгрөгний үйлчилгээний хураамж, 360319432 төгрөгний хөрөнгө борлуулсаны татварын орлогыг төвлөрүүлэн ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн А/429 тоот "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх мэдүүлэг, маягтын загварыг шинэчлэн батлах тухай" тушаалыг хэрэгжүүлэн шинэчлэгдсэн мэдүүлэг маягыг бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэглэж хэвшүүлэн ажиллаж ирлээ. Мэдүүлгийн загвар шинэчлэгдсэнээр иргэн хуулийн этгээдээр мэдүүлэг бөглүүлэхгүйгээр хурууны хээ, регистрийн дугаараар ePRS-2 мэдээллийн сангаас хэвлэн иргэнээр зөвхөн гарын үсэг зуруулдаг болсон нь иргэдэд оочир дараалал үүсгэхгүй чирэгдэлгүй үйлчлэх боломж нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Өмчлөгчийн мэдээлэл ePRS-2 мэдээллийн санд буруу цахимжсан 7 хувийн хэрэг, Газраас бусад үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэлийг бүртгэхдээ өмчлөгч болон хаягийн мэдээлэл буруу бүртгэсэн 1 хувийн хэрэг, Худалдах худалдан авах гэрээг бүртгэхдээ зөрүүтэй нотлох баримтаар бүртгэл хийсэн 1, Гүйцэтгэлийн хувь 40% гэснийг 100% гэж буруу бүртгэсэн 1 хувийн хэрэг, Хамтран өмчлөгч хасах хэлцэлийн мэдүүлэг, нотлох баримт ePRS-2 програмд бүртгэгдээгүй буюу цахимжаагүй 1 хувийн хэрэг нийт 11 хувийн хэрэгт хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн засвар өөрчлөлтийн бүртгэл хийсэн.

**2.1. Хууль хяналтын байгууллагыг мэдээ мэдээллээр хангаж ажилласан талаар:** Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээ, мэдээлэл, тайлбар, лавлагаа, хуулбарыг эрх бүхий байгууллагуудад олгоходоо "Улсын бүртгэлийн ерөнхий хууль", "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай" хууль, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам" болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хатуу баримтлан ажиллаж шүүхэд 5, Ховд аймаг дахь цэргийн гавьяаны одонт цагдаагийн газарт 190, Ховд аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид 85, авилгатай тэмцэх газарт 47-г нийт 322 иргэн, хуулийн этгээдийн талаарх лавлагаа, мэдээллийг хуулийн дагуу үнэн зөв гаргаж хүргүүлсэн байна.


Хөрөнгөтэй эсэх лавлагааг 45 иргэн хуулийн этгээдэд хууль журамд заасны дагуу үнэн зөв олгож ажилласан. Хууль хяналтын байгууллагын албан хүсэлтийн дагуу 5 иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн хувийн хэргээс хуулбар олгосон байна.

Ховд аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиас ирүүлсэн 13 удаагийн албан бичгийн дагуу 18 иргэн хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээж, 16 удаагийн албан бичгийн дагуу 23 иргэн хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэн ажиллаа.

**2.2. ЭХЭУБ-ийн тасаг: бусад ажлын талаар:** Сар бүрийн мэдээ тайланг ePRS-2 системээс газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ, газрын “Э”, “А” дугаар олгосон тухай мэдээ, ePRS-2 мэдээллийн санд засвар өөрчлөлт хийсэн тухай тэмдэглэл, орон сууц, хувийн сууцны анхны бүртгэл болон өмчлөх эрх шилжсэн талаарх мэдээ, орон сууцны барьцааны мэдээ зэргээр гарган тухайн сарын 25-ны өдрийн дотор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлж ирсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан 2 удаагийн онлайн сургалтанд тасгийн бүртгэгч нарыг бүрэн хамруулан чиглэл зөвлөмж авч ажилласан.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021.03.29-ны өдрийн 1/2215 тоот чиглэл, Эд хөрөнгийн хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2021.03.16-ны өдрийн 7/1707 тоот чиглэл, 2021.04.14-ны өдрийн 7/2734 тоот чиглэл, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргын 2021 оны 10/4958 тоот чиглэл зөвлөмжүүдийг тухай бүр тасгийн бүртгэгч нарт танилцуулан, гарын авлага хэлбэрээр өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.



Тайлангийн хугацаанд 318 хуулийн этгээдэд байгууллагын тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх хяналтын дугаар олгож, хуулийн этгээдийн нэр өөрчлөгдөж солигдох болон гэмтээсэн 44 ширхэг тэмдгийг хураан авч, архивт хүлээлгэн өглөө.

Сар бүрийн мэдээг цаг тухай бүрт нь гаргаж, холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлэн ажилладаг.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас 6 сарын 17-нд зохиогдсон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад оруулсан нэмэлт өөрчлөлтүүдээр онлайн сургалт, 5 сарын 19, 6 сарын 02-нд зохиогдсон монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтны сургалт, мөн 9, 10 дугаар сард УБЕГ-ын ХЭУБГ-аас зохион байгуулсан онлайн сургалтуудад хуулийн этгээдийн улсын бүртгэгчийг хамруулсан.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан “Шашны асуудал эрхэлсэн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд орж, тус зөвлөлийн хуралд 2 удаа сууж 2021 оны зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд саналаа оруулж батлууллаа.

Аж ахуй нэгж байгууллагын ээлжит тооллого эхэлсэнтэй холбоотой тооллогын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гишүүнээр орж холбогдох мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн санд шалгаж хамтарч ажилласнаас гадна аймгийн татварын хэлтэст улирал бүр шинээр байгуулагдсан болон өөрчлөлт орсон аж ахуй нэгжийн дэлгэрэнгүй судалгаа мэдээллийг тухай бүр нь хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн орлогын мэдээ, үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ 331, салбарын гэрчилгээ 6 тус тус зарцуулж санхүүтэй тооцоо хийж үнэт цаасны зөрчилгүй ажиллаа.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас авсан шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй байгаа хуулийн этгээдийн судалгаа, шашны байгууллагын судалгааг гаргаж, ахлах бүртгэгчид хүргүүлэв.



Аймгийн ЗДТГазрын санхүүгийн хяналт, аудитын газар, шүүх, цагдаагийн газар, татварын хэлтэс, Авлигатай тэмцэх газрын албан хүсэлтийн дагуу лавлагаа, судалгааг тухай бүр гарган хүргүүлж байна.

#### **4. Хяналт шалгалтын чиглэлээр**

Тус хэлтэс нь тайлангийн хугацаанд хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг батлуулан сумдын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон түүвэрчилсэн шалгалтыг хийж бүртгэлийн зөрчлийг тухай бүрд нь арилгуулан ажиллаа.

Мөн иргэдээс ирсэн өргөдөл хүсэлтийг хүлээн авч цаг хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна.

1. Хяналт тавьсан бүртгэлийн тоо - 918

А. Үүнээс иргэний бүртгэлийн чиглэлээр – 537

Б. ЭХЭУБ-ийн чиглэлээр - 158

В. Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр - 105

Г. Улсын бүртгэлийн архивын чиглэлээр - 118

2. Илрүүлсэн нийт зөрчил - 58

А. Иргэний бүртгэлийн чиглэлээр - 49

Б. ЭХЭУБ-ийн чиглэлээр - 8

В. Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 1

Г. Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 0

3. Зөрчлийн шийдвэрлэлт 130

А. Эрх бүхий хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн - байхгүй

Б. Шалгалтын явцад шийдвэрлэсэн зөрчлийн тоо - 2

В. Зөрчлийн хуулиар торгох шийтгэл оногдуулсан иргэн хуулийн этгээдийн тоо 739

4. Оногдуулсан торгуулийн хэмжээ 14,174,46 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.

Хэлтсийн хэмжээнд 3 бүртгэлийн чиглэлээр иргэдээс ирүүлж буй материал хүлээн авалт, бүртгэл хөтлөлтийн дэвтэр, өдөр тутмын бүртгэлийг түүвэрчлэн хянаж шалгаж арга зүйн зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байгаагаас гадна ЭХЭУБ нарын өдөр тутмын бүртгэл, анхны бүртгэл, барьцаат зээлийн гэрээний бүртгэлийн бүрдүүлсэн нотлох баримт, ePRS программд бүртгэл хөтөлсөн байдал зэрэгт хяналт тавьж зөвлөн туслаж байна.

Даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр сумдын бүртгэгч нарын бүртгэсэн бүртгэлийн эх нотлох баримтыг татан авч шалгаж, нэгжийн бүртгэгч нарт арга зүйн зөвлөгөөг тухай бүрд нь өгч ажиллаа.

Сар бүрийн мэдээ тайланг холбогдох дээд байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

##### **5. Дотоод ажил, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн чиглэлээр.**

Тайлант оны 1 дүгээр улиралд хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж хүргүүллээ.

Улирал бүр төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд явцын хяналт хийж, үр дүнг тооцож хэвшсэн.

МУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлыг хангаж, орон нутагт ерөнхийлөгчийн сонгуулийн ажлыг амжилттай зохион байгууллаа. МУЕ-ийн сонгуулийн хууль, УБЕГ-ын даргаас ирсэн чиглэлийн дагуу хэлтсийн дарга аймгийн сонгуулийн хороонд орж ажилласан.

Байгууллагын ажилтнуудын цаг ашиглалт, өдөр тутмын үйл ажиллагаанд хэлтсийн даргын зөвлөлийн бүрэлдэхүүн байнгын хяналт тавьж ажилладаг бөгөөд Ковид-19 цар тахлын дэгдэлт 4-9 сарын хооронд тус аймагт өндөр байсантай холбогдуулан хэлтсийн ажилтнуудыг ажлын өдрүүдэд 2 ээлжинд оруулж ажилласнаар тус хэлтсийн үйл ажиллагаа хэвийн явагдаж иргэдэд чирэгдэлгүй шуурхай үйлчилгээг үзүүлсэн.

Байгууллагаас гарч буй бүхий л мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь байгууллагын вэб сайтад байршуулж ажилласан.

Орон нутгийн ТВ, хэвлэл мэдээллийн байгууллагаар өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлж байдаг, 2021 онд 6 удаа үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл хүргэн ажилласан. Мөн байгууллагын цахим мэдээллийн буланд мэдээллийг байнга байршуулан ажилладаг.

Тайлант онд Улсын бүртгэлийн хэлтсийн 70432888 утсаар 160 иргэний хүсэлт саналыг сонсож 82 яаралтай асуудлуудыг шуурхай шийдвэрлэж ажилласан бөгөөд 78 иргэдэд арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

2021 онд хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ББНШАЗК-ын бүрэлдэхүүн 3 удаа хуралдаж байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлаж хэлтсийн иргэний баримтын архивт хадгалагдаж байгаа хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглах боломжгүй, архивт хадгалах шаардлагагүй 6608 ш баримт бичгүүдийг устгах санал хүргүүлэн ажилласан.

Устгах баримт бичгүүдийн жагсаалтанд тусгагдсаны дагуу УБХ-ийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийнхэн, дээр дурдсан бичиг баримтуудыг жагсаалт үйлдэн устгалд оруулан шатааж шатаах явцын зургийг авч баримтжуулан хүргүүллээ.

Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар иргэний баримтын архивын тооллого хийх явцад болон хэлтсийн агуулахаар ашиглагддаг контейнерийн баримт бичгийг цэгцлэн ангилан ялгах явцад үүссэн 22 нэр төрлийн баримт бичгүүдийг устгах саналыг Улсын бүртгэлийн нэгдсэн архивт хүргүүллээ.



Тайлант оны жилийн эцсийн байдлаар иргэдээс нийт 92 иргэнээс өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс:

- Иргэний бүртгэлийн чиглэлээр- 26
- Бүртгэлийн хяналтын чиглэлээр-57
- Албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт-9

Өргөдөл гомдлын мэдээг сар бүр хууль журамд заасан хугацаанд хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант онд 748 албан бичиг харъяа байгууллага болон холбогдох бусад байгууллагаас ирж 1124 албан бичгийг харъяа дээд байгууллагад болон холбогдох бусад байгууллагад хүргүүлэн ажилласан байна.

2021 онд хэлтсийн ажилтнуудын хурлыг 24 удаа, даргын зөвлөлийн хурлыг 10 удаа хийж, хурлаас гарсан шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан бөгөөд хурлын тэмдэглэлийг бүрэн хөтөлж архивласан.

### **6.Төсөв санхүүгийн чиглэлээр**

2021 онд байгууллагын өмч хөрөнгийн тооллогыг 1 удаа явуулсан бөгөөд ямар нэгэн зөрчил болон үнэт цаасны дутагдал гараагүй болно.

Батлагдсан төсвийг зүйл заалтаар нь үр дүнтэй захиран зарцуулж, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.


Төсөв хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээ мэдээллийг хэлтсийн вэб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн ба шилэн дансны хуулийг мөрдөн ажиллаж байна.

2021 оны санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулсан ба санхүүгийн гарсан алдаа дутагдлаа засаж залруулан тавигдсан 3 актны 2 актыг бүрэн барагдуулж тэтгэвэрт гарсан ажилтанд тавигдсан 1 актыг тухайн ажилтан буцаан хийх боломжгүй байгаа талаараа аймгийн аудитын газарт хүсэлтээ хүргүүлсэн.

Мөн Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн зардлыг зүйл заалтаар нь ямар нэгэн зөрчилгүй захиран зарцуулсан.

## **7. Мэдээлэл технологи, техник тоног төхөөрөмжийн талаар**

Тайлант оны 1 дүгээр сард багтаан онлайн сүлжээнд холбогдоогүй байсан Булган, Үенч, Алтай, Зэрэг, Цэцэг, Дуут Буянт сумдуудад ОНЛАЙН сүлжээ тавьж аймгийн хэмжээнд 100% сүлжээнд холбогдлоо.



УБЕГ-т Япон улсын КОЙКА-н буцалтгүй тусламжаар хэрэгжсэн “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг дэмжих” төслийн хүрээнд 17 сумын 19 улсын бүртгэгчдэд иж бүрэн компьютер, олон үйлдэлт принтер, зургийн аппарат, хурууны хээ уншигч, скайнер зэрэг 5 төрлийн тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгснөөр улсын бүртгэгч нар иргэний улсын бүртгэлийн шинэчилсэн системдээ шинэ тоног төхөөрмөө ашиглан иргэдэд үйлчилгээ үзүүлж эхэллээ.



Мөн аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөнөөс 5 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэлээ.

### **8. Эрх зүй, сургалт сурталчилгааны талаар**

Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалтуудад албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж орон зайнаас үл хамааран бүх нэгжүүдэд цахим сургалтын системийг хэрэгжүүлж эхэллээ. Ингэснээр улсын бүртгэлийн байгууллагын ажилтан албан хаагч, улсын бүртгэгч нарыг чадавхжуулах ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

УБЕГ-аас иргэний улсын ахлах бүртгэгч нарт онлайн цахим сургалтыг -7 удаа, эрх-зүйч мэргэжилтэй улсын бүртгэгч нарт ЭХЭУБ-ийн чиглэл олгох онлайн цахим сургалтыг 11 сарын байдлаар 10 гаруй удаа зохион байгуулахад бүрэн хамрагдсан болно.

2021 оны 09 сарын 06-наас эхлэн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй төрийн албан хаагчдыг чадавхижуулах Пүрэв гаригийн 10 удаагийн сургалтанд нийт албан хаагчид бүрэн хамрагдаж байна.




УБЕГ-аас 2021 оны 09 дүгээр сарын 8-9 ны өдрүүдэд Говь-Алтай, Ховд аймгийн улсын бүртгэлийн нийт албан хаагчдад бүсчилсэн сургалт зохион байгуулж хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулсан.






Зэрэг сумын улсын бүртгэгчийн оронд түр томилогдсон О.Отгонбалыг хэлтэст ирүүлэн сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулан Жаргалант сумын улсын бүртгэгч нарыг дагалдуулан 5 өдрийн ажил дээрх дадлага хийлгүүлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн 91 хэсэгт ажиллах итгэмжлэгдсэн ажилтанг хууль эрх зүйн мэдээллээр хангах тэдгээртэй гэрээ байгуулахад анхаарах асуудлын талаар чиглэл өгөх зорилгоор итгэмжлэгдсэн ажилтнуудад хэлтсийн дарга С.Хоролсүрэн, Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч Б.Эрдэнэбулган нар онлайн сургалтыг 2 хэсэг болгон зохион байгуулсан.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн тухай хуулийг тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зохион сонгогчийн ирц бүртгэлийн программын болон эрх зүйн сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Тус сургалтын багийн ахлагч УБЕГ-ын Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын дарга С.Оюунгэрэл, УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Б.Нарангэрэл, УБЕГ-ын МТГ-ын сүлжээний инженер Э.Төртогтох нар сургалтыг амжилттай удирдан зохион байгуулан чиглэл өгч техник программын дадлага хийлгүүллээ.



Аймгийн сонгуулийн 91 хэсэгт ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудад сургалтын хөтөлбөр хуваарийг танилцуулан түгээж сургалтанд итгэмжлэгдсэн ажилтангуудыг 100% хамруулан оролцууллаа





КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалтын танхимыг ариутган 2 цаг тутамд агаар оруулан халдваргүйжуулан, сургалтанд оролцогчдын биеийн халууныг хэмжиж гар ариутгах хэрэгсэл тавьж, амны хаалт зүүлгэх арга авч ажилласан.

2021 оны 11 дүгээр сарын 02 ны өдөр Монгол улсын хүний эрхийн үндсэн комиссын Ховд аймаг дахь ахлах шинжээч М.Өнөрмөөгаар "Хүний эрхийн үндсэн ойлголт" сэвдээр нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан





Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Авлигатай тэмцэх, Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг, Хүний эрхийн тухай сургалтуудыг холбогдох газар хэлтсийн мэргэжилтнүүдээр хийлгэж мэдээ мэдээлэл авч байна.





Монгол улсад улсын бүртгэлийн байгууллага үүсэн байгуулагдсаны 81 жил, бүртгэлийн ажилтны өдрийг угтаж Жаргалант сумын 3 сургуулийн сурагчдын дунд “Бүртгэл миний амьдралд “сэдэвт хууль сурталчлах арга хэмжээ зохион байгууллаа.



Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд улсын бүртгэлийн багц хуулийг сурталчлах, сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төрийн байгууллага, сургуулиудын хоорондын харилцаа уялдааг бэхжүүлэх зорилгоор АХА тэмцээнийг зохион байгууллаа. Тус АХА тэмцээнд ерөнхий боловсролын сургуулийн 40 хүүхэд авъяас оюун ухаанаа дайчлан оролцсоноос 12 жилийн Лабортори 1 дүгээр сургуулийн сурагч Т.Буянхишиг 1-р байр, Цаст-алтай сургуулийн сурагч Д.Гансэлэм 2-р байрыг тус тус эзэллээ.



## **9.Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан талаар**

2021 онд Аймгийн удирдлагууд болон бусад байгууллагатай хамтран нилээдгүй ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**9.1 Аймгийн Засаг даргаар дараах үйл ажиллагааг болон үйл ажиллагааны зардлыг шийдвэрлүүлсэн.**

9.1.1. Байгууллагын барилгын газрыг шийдвэрлүүлсэн.

9.1.2. Аймгийн засаг даргын нөөцөөс 5 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж, эд зүйлийг шийдвэрлүүлсэн.

9.1.3. Үйлчилгээний заалны 4 цонхны хөшиг, 2ш хувилагч канон, Санхүүд 1ш, ЭХЭУБ-тасагт 1ш нийт 2ш компьютер шийдвэрлэсэн.



**9.2. Аймгийн Засаг даргын тамгын газраар дараах үйл ажиллагааны зардлыг шийдүүлэн ажиллаа.**

9.2.1. Архивын өргөтгөлийн 1 өрөөг ЗДТГ-аас засварын хөрөнгийг шийдүүлэн хийлгүүлсэн бөгөөд архивын байрны парыг шинэчилсэн. 2 сейф болон 3 тавиурыг мөн шинэчилж байршуулсан.





9.2.2. Барилга барих техникийн үзүүлэлт болон Геологийн дүгнэлт, ОБГ, МХГ-ын дүгнэлтүүдийн үнэ тарифийн асуудлуудыг шийдүүлсэн.

9.2. 3. Архивын өргөтгөлийн 1 өрөөний засвар шийдүүлсэн

9.2.4. Байгууллагын гадна талын урсгал засвар хийлгүүлсэн.



9.2.5.Архивын 2 паарыг солиулсан.



### **9.3.Бусад байгууллагатай хамтран ажилласан талаар:**

9.3.1. Нээлттэй-Хаалттай хорих ангид хоригдож буй иргэдэд мэдээлэл хийж иргэний үнэмлэхгүй 11 хоригдуудыг үнэмлэхжүүллээ.






9.3.2. Ховд аймаг дахь ШШГ-457 анги нээлттэй-хаалттай хорих ангийн тусламжаар хэлтсийн ажилтнуудын ажлын завсарлага, чөлөөт цагаар түр амрах 1 өрөөг бүрэн тохижууллаа.



9.3.3. Аймгийн ЦГ-тай хамтран дэлгүүр цэнгээний газруудаар хяналт шалгалт хийж 34 иргэний үнэмлэхийг хурааж авсан.



9.3.4. БОЭТ-тэй хамтран бүх ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамрууллаа.

9.3.5. Жаргалант сумын 2 улсын бүртгэгчийг хэлтсийн байрнаас нүүлгэж тус суманд байрлуулхад шилэн кабелийн 4 корын 860м утас буюу 1,756, 000 төгрөгийг сумын ЗД-ын нөөц хөрөнгөөс шийдүүлж татуулсан.

9.3.6. Булган сумын 2 улсын бүртгэгчдэд 1 канон, мөн юнителийн 1 антенийг бүрэн суурилуулах ажлыг тус сумын ЗДТГ-аар шийдвэрлүүлээ.




### ***10.Идэвхи санаачлага, шинэлэг ажлын талаар***

Тайлант онд хэлтсийн ажилтнуудын идэвхи санаачлагыг өрнүүлэх, байгууллага дотроо болон гадагшаа иргэдэд чиглэсэн шинэлэг ажлуудыг сар бүр хийхээр төлөвлөж, зорилт дэвшүүлэн ажиллаа.

Оны эхнээс Иргэний болон ЭХЭУБ-ийн хоёр тасгийн дунд байгууллагадаа шинэлэг ажил зохион байгуулах 1 сарын уралдаан зарласнаар Иргэний бүртгэлийн тасаг байгууллагын үйлчилгээний зааланд үйлчилгээ авч буй иргэдэд байнгын давтамжаар E-Mongolia апп-аар үндэсний энгийн гадаад паспорт болон иргэний үнэмлэх хэрхэн захиалж болох талаар мэдээлэл өгч байх ажлыг санаачлан ТВ-ийн том дэлгэц байрлуулан минут тутам мэдээлэл явуулж эхэлсэн.

Иргэд үйлчилгээ авах хооронд дээрхи мэдээлэл нь иргэдэд хамгийн ойроос мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.



ЭХЭУБ-ийн тасаг нь байгууллагад үйлчилгээ авахаар ирсэн жирэмсэн болон нялх хүүхэдтэй иргэдэд үйлчилгээ авах тохилог орчин бүрдүүлэх, мөн хэлтсийн ажилтнуудын түр алжаал тайлж чөлөөт цагаа өнгөрөөр 1 өрөөг тохижуулах санал ирүүлснийг ажил болгож хамтран ажилладаг ШШГ-457 ангийн тусламжаар тохижуулсан.



Хэлтсийн архивт байгаа 3 бүртгэлийн бүх хувийн хэргийг тоолж дуусгасан. Тодорхойгүй гэсэн нэр бүхий 12 хайрцаг хувийн хэргийг нэгбүрчлэн мэдээллийн санд шалгаж, шалгасан хувийн хэргүүдийг эксель программ дээр шивж нэгтгэлээ.

Хэлтсийн ИБ-ийн тасгийн бүртгэгч нарт хөдөөгийн 16 сумдыг хувиарлан өгч 2005 онд төрсөн 2021 онд 16 нас хүрэх хүүхдүүдийн төрсний бүртгэлүүдийг мэдээллийн санд шалгуулах ажлыг хийсэн бөгөөд хэлтсийн 5 бүртгэгч нийт 1160 хүүхдийн мэдээллийг нэг бүрчлэн шалгаж мэдээллийн санд өөрийн болон эцэг эхийн нэрний, ургийн овгийн зөрчилтэй 271 хүүхдийн зөрчлийг бүрэн арилгалаа.

Байгууллагын орчны тохижилтонд анхаарч аймгийн ЗДТГ-аар санхүүжилтийг шийдүүлэн гадна талын засварыг бүрэн хийлгүүлж, урд хэсгээр нь мод тарьсан.

Аймгийн удирдлагууд болон орон нутгийн бусад байгууллагуудадтай хамтарч үндсэн ажлууд болон сургалт сурталчилгааны бусад ажлуудыг хийснээс гадна хөрөнгө оруулалтын ажлуудыг хийсэн тухай тайлангийн 9 дүгээр бүлэг дээр тодорхой бичсэн.

Улсын бүртгэлийн 81 жил, улсын бүртгэлийн ажилны өдрийг угтаж аймгийн хэмжээнд сумдын бүх сургуулиудын сурагчдын дунд “Зөрчилгүй бүртгэл-миний ирээдүй” сэдэвт нэг сарын аяныг зохион байгуулж ахлах ангийн сурагчдын дунд бүртгэлийн хууль журмыг таниулж ойлголт мэдээлэл өгөх ажлыг хийж “АХА” тэмцээнийг зохион байгууллаа.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Иргэний андгай өргөх” ёслолыг аймгийн хэмжээнд зохион байгуулж аймгийн Засаг дарга болон бусад удирдлага, сумдын засаг дарга нарыг оролцуулан хийсэн.







Зэвсэгт хүчний 123 дугаар ангитай хамтран 2020 оны хоёрдугаар ээлжээр татагдан ирсэн хугацаат цэргийн албан хаагчдаас бичиг баримтгүй, хүчин төгөлдөр бус хугацаа нь дууссан бичиг баримттай цэргийн албан хаагчдыг бичиг баримтжуулах ажлыг хамтран зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 2 цэргийн албан хаагч, цахим үнэмлэхгүй 10 хугацаат цэргийн албан хаагчдыг нь бичиг баримтжууллаа.



Төлөвлөгөөт сургалтуудаас гадна иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааны гарын авлага материалыг өөрийн нөөц боломжинд тулгуурлан хэвлэж үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд хүргэн ажиллаж дээрхи ажлын хүрээнд тайлант онд 1000ш боршур гарын авлага, зөвлөмж хэвлэж тараалаа.





Хэлтсийн эцэг эхийн зөвлөлөөс “Хүүхдэд ээлтэй – эко аюулгүй орчин” аян өрнүүлж хэлтсээрээ Ерөнхийлөгчийн тэрбум мод тарих ажлын хүрээнд 150ш модыг өөрсдийн санхүүгээр суулгац авч тарилаа.



Ахмадын өдрийг тохиолдуулан хэлтсийн ахмад ажилтнуудад байгууллагын хамт олноос гарын бэлэг хүргүүлж тэдний санал хүсэлтийг сонсож ажлын туршлагыг судлах ажлыг зохион байгууллаа.



Хөдөөгийн сумдын иргэдэд бүртгэлийн үйл ажиллагаа, хууль журмыг сурталчлах ажлыг сумдын Засаг даргатай хамтран зохион байгуулж зарим сумдын багийн хуралд улсын бүртгэгч нар оролцлоо.



Аймгийн ЗДТГ-тай хамтран “Та хичээ-Бид зүтгэе” уриан дор аймгийн Засаг даргатай нэг баг болж аймгийн төвөөс алслагдсан Алтай давааны цаадах 3 сумдад хүрч ажиллаа.



2021 оны 5 дугаар сард тус аймагт ажилласан ХЗДХ-ийн сайд, УБЕГ-ын дарга нарт байгууллагын архив болон байгууллагын бусад ажлыг танилцуулж, УБЕГ-ын дарга, аймгийн засаг дарга нар тус хэлтсийг байртай болгох асуудлыг шийдвэрлүүлэх талаар салбарын сайдад уламжилж улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр болсон.



2021 оны 6 дугаар сард барилгын зураг төсөл хийх, баригдах барилгын газрыг үзэж мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулахаар ХЗДХ-ийн яамны болон салбар байгууллагаас бүрдсэн ажлын хэсгийг ирхэд хүлээн авч орон нутагт хийгдэх ажлуудыг бүрэн шийдвэрлүүлсэн.

Тус хэлтсийн Мөст сумын улсын бүртгэгч Б.Гал-Одод УБЕГ-аас шинэ гэр өгч улсын бүртгэгч Гал-Од гал голомтоо бадраан хуримаа хийсэн.



Мөн УБ хотоос геологийн дүгнэлт гаргуулахаар мэргэжлийн багийг ирүүлж геологийн дүгнэлт гаргуулах төсөв мөнгийг аймгийн ЗДТГ-аар шийдвэрлүүлэн ажиллаа.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран шинээр гэр бүл болж буй хосуудад гэрлэлтийн баталгаа гардуулах ажлыг зохион байгуулж залуу хосуудад гэр бүлийн хуулийн талаар мэдээлэл өгч “Гэрлэх ёслолын ордон”-ны үйл ажиллагааг жигдрүүлэн ажиллаж байна.



### **ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТЫН ТАЛААР:**

- ✚ Бүртгэлүүдийн хувийн хэргүүдийг мэдээллийн санд үнэн зөв цахимжсан эсэхэд хяналт тавьж нэг бүрчлэн шалгаж цэгцлэх.
- ✚ 2 тасгийн бүртгэгчид, хуулийн этгээдийн бүртгэгч нарыг ажлын чиг үүрэгтэй нь холбоотой хууль тогтоомжийг сайтар судлуулан хэрэгжүүлж, авлигаас ангид байж, харилцаа хандлага, ёс зүйг дээдлэн ажиллахад хяналт тавих, арга зүйгээр хангах.
- ✚ Ажлын байрандаа улсын бүртгэгч бүр өөрийгөө хөгжүүлэхэд бүхий л талаар дэмжиж туслах
- ✚ ТАХ бүр ажлын байрны сахилга хариуцлагыг өндөржүүлж, үр бүтээлтэй, иргэдэд ээлтэй, ёс суртахуунтай төрийн үйлчилгээг үзүүлэхийг чухалчлах.

- ✚ Байгууллагын санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, зөрчил дутагдалгүй ажиллах
- ✚ Гар утаснаасаа бүртгэлийн үйлчилгээ авах цахим системийн талаар иргэдэд байнга мэдээлэл өгч, арга зүйгээр хангаж цахимаар авч болох бүртгэлийн тоог нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: ХЭЛТСИЙН ДАРГА

С.ХОРОЛСҮРЭН